



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭЭДЭЭ

№229 /438/

2022.12.20

Цаг үе, үйл явдал

ЗХЖШ-ЫН УДИРДЛАГУУД КАБЦК-Д АЖИЛЛАА



ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, нэгдүгээр орлогч дарга Ж.Өсөхбаяр тэргүүтэй албаныхан Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлалд ажиллалаа. Тэднийг Кибер аюулгүй байдлын цэргийн командлалын бие бүрэлдэхүүн хүлээн авч албандаа хийж хэрэгжүүлж буй ажил, өдөр тутмын үйл ажиллагаагаа танилцуулсан юм.

Энэ үеэр тус командлалын бүрэлдэхүүн тулгамдаж буй асуудал, ололт амжилтаа ЗХЖШ-ын удирдлагуудад танилцуулж, өмнөө тавьсан зорилго, цаашид Монгол Улсын аюулгүй байдлын урт болон дунд хугацааны зорилтод тулгуурласан төсөл, хөтөлбөрүүдээ үе шаттайгаар хэрэгжүүлж, чадварлаг хүний нөөц, шилдэг техник технологи, баталгаатай орчныг бий болгохоор зорьж буй тухайгаа онцлон дурдсан юм.

ҮБХИС-ИЙН ХАМТ ОЛОН 2022 ОНД 97,7 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ АЖИЛЛАВ



Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит, Сүхбаатарын ба Байлдааны болон Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хамт олон 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа дүгнэхийн зэрэгцээ ирэх оны зорилго, зорилтоо тодорхойллоо.

Үндэсний батлан хамгаалахын Их сургуулийн эрдмийн хамт олон сургуулийнхаа урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан төлөвлөсөн 2022 оны зорилго, зорилтуудаа нэгдсэн удирдлага, хамт олны идэвхтэй оролцоотойгоор 97,7 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна. Тухайлбал Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Монгол цэргийн өдөр-Зэвсэгт хүчний 101 жилийн

ой, Монгол Улс Энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан томоохон арга хэмжээнүүдэд бие бүрэлдэхүүн амжилттай оролцсон талаар Цэргийн алба, сургалт хариуцсан тэргүүн дэд захирал доктор, хурандаа Б.Энхзоргол тайлагнав.

Тус хамт олон нь өнгөрсөн хичээлийн жилд АБДС, ЦНДС, ЦХК, БХМСҮТ-ийн нийт 700 гаруй төгсөгчдийг 99.4%-ийн амжилт, 71.2%-ийн чанартайгаар төгсгөн захиалгат байгууллагуудад хүлээлгэн өгсөн бол 2022-2023 оны хичээлийн шинэ жилд иргэний мэргэжлээр 7 хөтөлбөрт 170 орчим оюутан, цэргийн мэргэжлийн 4 жилийн 13 хөтөлбөрт 140 гаруй сонсогч, мэргэжлийн боловсролын

хөтөлбөрт 122 сонсогч, сурагч тус тус элсүүлжээ.

Мөн энэ үеэр ҮБХИС-ийн захирал профессор, бригадын генерал П.Жаргалан бие бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ улсын болон салбарын чанартай шинэ бүтээл, шилдэг технологи, инновацийн уралдаан тэмцээнүүдэд эрдэмтэн багш, сонсогч, оюутан, сурагчид оролцож тэргүүн болон дэд, шагналт байруудыг эзэлсэн амжилтаар ирж буй шинэ оноо утгаж байгаад баяртай байгаагаа илэрхийлээд ирэх онд байгууллага, хувь хүний идэвх санаачилгаар үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа тодорхойлон чанарын өндөр түвшинд хэрэгжүүлэхийг уриалсан юм.

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 124 ДҮГЭЭР АНГИ ТЭРГҮҮЛЭВ



Өндөр хурдны радио телеграфын 2022 оны улсын аварга шалгаруулах тэмцээн өнгөрөгч долоо хоногт явагдаж дүнгээ гаргалаа. Төрийн цэргийн байгууллагууд болон

өндөр хурдны радио телеграф сонирхогчид олноор оролцсон энэхүү тэмцээнийг хүлээн авалт, нэвтрүүлэг, тэмцээний холбоо барих /MR/ болон дуудлага хүлээн авах /RUFZ/

гэсэн төрлүүдээр явуулсан бөгөөд тэмцээний ангилал, төрөл бүрт болон эдгээр дөрвөн төрлийн нийлбэр оноогоор багийн дүнг гаргаж урамшуулав.

Тэмцээний нэгдсэн дүнгээр эмэгтэй ангиллын тэргүүн байрт олон улсын хэмжээний мастер Н.Орлого, дэд байрт Б.Хишигчулуун, гутгаар байрт спортын дэд мастер Б.Учралбаяр нар шалгарсан бол эрэгтэй ангиллын тэргүүн байрыг спортын мастер П.Баттөр, дэд байрыг олон улсын хэмжээний мастер Э.Чинзориг, удаах байрыг Б.Сансызбай нар эзэлж, алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагналын эзэд боллоо.

Энэ удаагийн тэмцээнд багийн нэгдсэн

дүнгээр Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн баг тамирчид тэргүүн байрыг эзэлж цом, алтан медаль, мөнгөн шагнал хүртсэн бөгөөд дэд байрт Зэвсэгт хүчний 189 дүгээр анги, гуравдугаар байрт Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн баг тамирчид шалгарсан юм.

Сонирхуулахад, энэ оны өндөр хурдны радио телеграфын улсын аварга шалгаруулах тэмцээнийг тус холбооны удирдах зөвлөлийн тэргүүн, олон улсын хэмжээний мастер Ж.Батжаргал, олон улсын хэмжээний мастер Д.Нэхийт нар санхүүжүүлэн зохион байгуулсныг онцолж, баяр хүргэе.

Ахлах дэслэгч Г.ДАВААБАЯР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-19	-29

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.452	3.456
EUR	3.672	3.685
CNY	492	495
RUB	51.50	52
JPY	25.45	25.70
KRW	2.64	2.66

ЗУРХАЙ

2022.12.20 / МЯГМАР ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 27

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН
ГАХАЙ САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ
УЛААГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:
Өлзийтэй сайн
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.38-17.01
Барилдлага:
Арвидах
Шүтэн барилдлага:
Өтлөх үхэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн., эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.

КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 658,223,769

Эдгэрсэн

Нийт: 631,989,024

Нас барсан

Нийт: 6,673,416

